



Дотоод хэрэглээнд



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн
20 тоот Тогтоолын Хавсралт

ИНВЕСКОР ББСБ-ЫН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ БОДЛОГО

IC-85 V-2.0

2022 он

<i>Хамрах хүрээ:</i> ИНВЕСКОР ББСБ болон мэдээлэх үүрэг бүхий охин компаниуд	<i>Хариуцах эзэн:</i> Инвескор ББСБ-ын Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар
<i>Хувийг хадгалах:</i> Төлөөлөн удирдах зөвлөл, Хууль, Эрсдэлийн Удирдлагын Газар	<i>Танилцах:</i> ИНВЕСКОР ББСБ ХК болон мэдээлэх үүрэг бүхий охин компаниудын нийт ажилтнууд
<i>Хүчинтэй хугацаа:</i> 2022 оны 06-р сарын 22-ны өдрөөс эхлэн	<i>Хуудасны тоо:</i> 6 хуудас
<i>Дараагийн үнэлгээ хийх огноо:</i> 2023 оны 06 сарын 22-ны өдөр	
<i>Журмын дугаар:</i> IC-85	<i>Хувилбар:</i> V-2.0

Өөрчлөлтийн түүх

#	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1.	V-1.0	2020.10.05	МУТС-ээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөр баталсантай холбоотой өөрчлөлт оруулав.
2.	V-2.0	2022.06.22	Компанийн засаглалын кодексын шинэчлэлтэд нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулав.
3.			
4.			
5.			

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	1
2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ.....	1
3. МУСТ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ	3
4. ХАМГААЛАЛТЫН БҮСҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ	4
5. ДОТООД ХЯНАЛТЫН ХӨТӨЛБӨР	5

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого” /цаашид “Бодлого” гэх/ нь Инвескор ББСБ ХК болон түүний охин компаниуд болох Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд /цаашид нийтэд нь “ББСБ” гэх/-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй /цаашид “МУТС” гэх/ тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаанд баримтлах бодлого, зарчмыг тодорхойлсон баримт бичиг байна.
- 1.2. ББСБ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон эрх бүхий байгууллагаас баталсан бусад эрх зүйн актыг удирдлага болгож ажиллана.
- 1.3. ББСБ-ын гадаад дахь охин компани нь үйл ажиллагаа явуулж байгаа улсынхаа хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхээс гадна Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль болон энэхүү бодлогыг баримтлан хэрэгжүүлж ажиллана.
- 1.4. ББСБ нь МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр болон бусад холбогдох журам, заавар, аргачлалыг боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан хэрэгжүүлэх ба тэдгээр нь энэхүү бодлогын салшгүй хэсэг байна.

2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Бодлогод дурдагдсан нэр томьёог доор утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:
 - 2.1.1. **Мөнгө угаах** гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;
 - 2.1.2. **Терроризмыг санхүүжүүлэх** гэж террорист байгууллага, террорист хүн, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсныг;
 - 2.1.3. **Харилцагч** гэж ББСБ болон түүний охин компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүлээн авч буй иргэн, хуулийн этгээдийг;
 - 2.1.4. **Хамтран ажиллагч** гэж ББСБ болон түүний охин компаниудтай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж буй иргэн, хуулийн этгээдийг;
 - 2.1.5. **Харилцагчийг таньж мэдэх ажиллагаа** гэж албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан тухайн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг;
 - 2.1.6. **Эрх бүхий байгууллага** гэж МУТС-тэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий санхүүгийн зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албыг;

- 2.1.7. **Мэдээлэх үүрэг** гэж өөрийн дотоод үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээнд мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэх, терроризмыг санхүүжүүлж болзошгүй нөхцөл байдлын эрсдэлийг үнэлж дүгнэх, урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлэх, үр дүнг эрх бүхий байгууллагад тайлагнах, сэжигтэй гүйлгээг цаг алдалгүй мэдээлэхийг;
- 2.1.8. **Сэжигтэй гүйлгээ** гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл МУТС-тэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн МУТС-тэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг;
- 2.1.9. **Бэлэн мөнгөний гүйлгээ** гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг;
- 2.1.10. **Бэлэн бус мөнгөний гүйлгээ** гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, никасс, төлбөрийн карт, цахим төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;
- 2.1.11. **Хөрөнгө** гэж аливаа этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юмс болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлс, эрхийг;
- 2.1.12. **Комплаенсын ажилтан** гэж ББСБ болон охин компанийн гүйцэтгэх удирдлагаас томилсон МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажилтныг;
- 2.1.13. **Ажилтан** гэж харилцагчтай санхүүгийн харилцаа үүсгэх болон бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж харилцагчийг таньж мэдэх ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтныг;
- 2.1.14. **Улс төрд нөлөө бүхий этгээд** гэж нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тодорхойлсон этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;
- 2.1.15. **Эцсийн өмчлөгч** гэж:
 - 2.1.15.1. Харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

- 2.1.15.2. Харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 2.1.15.3. Хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг тус тус ойлгоно.

3. МУСТ-ТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 3.1. ББСБ нь МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын хүн, хуулийн этгээд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй бизнесийн харилцаа үүсгэхгүй.
 - 3.1.2. Хориг жагсаалтад буй улс орнуудад бизнесийн үйл ажиллагаа явуулахгүй.
 - 3.1.3. Халхавч банк буюу бодитоор оршин тогтнодоггүй банк, санхүүгийн байгууллагатай харилцаа тогтоохгүй.
 - 3.1.4. Бизнесийн үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй, өөрийн мэдээлэл болон орлогын эх үүсвэрээ нуун дарагдуулсан гэж үзсэн хүн, хуулийн этгээдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхгүй.
 - 3.1.5. МУСТ бодлого журамгүй эсхүл урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тогтолцоогүй банк санхүүгийн байгууллагад данс нээхгүй, эх үүсвэр байршуулахгүй.
 - 3.1.6. ББСБ болон охин компаниудын Гүйцэтгэх захирал нь МУСТ хариуцсан чиг үүрэг бүхий Комплаенсын ажилтныг томилох, чөлөөлөх, түүний эрх үүргийг тодорхойлох ба шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж ажиллана.
 - 3.1.7. ББСБ нь өөрийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны дагуу МУТС эрсдэлийг жил тутамд үнэлэх ба холбогдох хууль болон зохицуулагч байгууллагын журамд заасан аргачлалын дагуу өөрт учирч болох эрсдэлийг тодорхойлж тэдгээрийг үр дүнтэй удирдах хяналтын тогтолцоог бий болгож ажиллана.
 - 3.1.8. ББСБ нь МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллагч болон харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгч болон улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана.
 - 3.1.9. ББСБ нь өөрөө оролцогч нь болох санхүүгийн нэгдлийн өөр нэг оролцогч болох гуравдагч этгээдийн ХТМ үйл ажиллагааг гүйцэтгэх, эсхүл ХТМ үйл ажиллагааг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд

холбогдох хууль болон зохицуулагч байгууллагаас тавьсан шалгуур нөхцөлүүдийг хангаж ажиллана.

- 3.1.10. ББСБ нь үйл ажиллагаандаа шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэ сувгийг нэвтрүүлэхийн өмнө тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэрийн МУТС зорилгоор ашиглагдах эрсдэл болон өмнө байсан бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл шинэ технологийг нэвтрүүлснээр хэрхэн өөрчлөгдөхийг үнэлж, тухайн эрсдэлийг үр дүнтэй удирдах хяналтыг хэрэгжүүлнэ.
- 3.1.11. ББСБ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл болон эрх бүхий байгууллагаас МУТС, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбогдуулан гаргасан санхүүгийн хориг арга хэмжээг МУТС-тэй тэмцэх тухай хууль болон бусад холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.
- 3.1.12. ББСБ нь МУТС-тэй тэмцэх хуульд заасан мэдээлэх үүргийн дагуу харилцагчийн хөрөнгө, бэлэн мөнгөний гүйлгээ, сэжигтэй гүйлгээ болон бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 3.1.13. ББСБ нь харилцагчийг таньж мэдэх ажиллагааны хүрээнд цуглуулсан бүхий л мэдээлэл, баримт бичиг, гэрээ, санамж бичиг, дансны мэдээлэл, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материалыг тухайн харилцагчтай харилцаа дуусгавар болсноос хойш 5 (тав)-аас доошгүй жил хадгална.

4. ХАМГААЛАЛТЫН БҮСҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

- 4.1. Хамгаалалтын нэгдүгээр бүс (Бизнесийн нэгж, салбар, төлөөлөгч) нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
 - 4.1.1 МУТС-тэй тэмцэх бодлого, МУТС-ээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөр, холбогдох журам, заавруудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хэрэгжүүлэх;
 - 4.1.2 Харилцагчийг таньж мэдэх ажиллагааг гүйцэтгэж, холбогдох баримт бичгийн бүрдлийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн авах;
 - 4.1.3 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, цаг алдалгүй мэдээлэх;
 - 4.1.4 Комплаенсын ажилтанд холбогдох тайлан, мэдээллийг цаг тухайд нь гаргаж хүргүүлэх;
 - 4.1.5 МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой сургалтуудад заавал хамрагдах.
- 4.2. Хамгаалалтын хоёрдугаар бүс (Комплаенсын ажилтан) нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
 - 4.2.1. МУСТ-тэй тэмцэх үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ, олон улсын байгууллагаас гаргасан хориг жагсаалтуудын мэдээллийг тухай бүр ажилтнуудад бэлтгэн хүргүүлэх, мэдээлэх;
 - 4.2.2. Бодлого, дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах, заавар зөвлөмжөөр ажилтнуудыг хангах;
 - 4.2.3. МУСТ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд мониторинг хийх;

- 4.2.4. Санхүүгийн хориг жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй бизнесийн харилцаа үүсгэсэн эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээг авах;
 - 4.2.5. Мэдээлэх үүргийн дагуу холбогдох тайлан, мэдээллийг эрх бүхий байгууллагуудад мэдээлэх, хүргүүлэх;
 - 4.2.6. Эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу харилцагчийн хийсэн болон хийх гэж буй гүйлгээг түдгэлзүүлэх эсэхийг холбогдох ажилтанд мэдээлэх;
 - 4.2.7. Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захиралд МУТС-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - 4.2.8. Сургалт зохион байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, МУТС-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой бүхий л мэдээллээр хангах;
 - 4.2.9. Аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулж буй дотоод бодлого, журмууд нь энэхүү бодлогод нийцсэн эсэхэд хяналт тавих;
 - 4.2.10. МУТС-ээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагатай харилцах, тайлан мэдээг хүргүүлэх.
- 4.3. Хамгаалалтын гуравдугаар бүс (Дотоод аудит) нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
- 4.3.1. МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг үнэлж, дүгнэлт өгөх;
 - 4.3.2. МУТС-ээс урьдчилан сэргийлэх зорилгоор Комплаенсын ажилтантай хамтран ажиллах.

5. ДОТООД ХЯНАЛТЫН ХӨТӨЛБӨР

- 5.1. ББСБ нь МУТС-тэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалт, өөрт учирч болох эрсдэлийн түвшинд нийцүүлэн өөр өөрийн дотоод хяналтын хөтөлбөрийг баталж хэрэгжүүлнэ.
- 5.2. Дотоод хяналтын хөтөлбөрийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална.
- 5.3. Дотоод хяналтын хөтөлбөрт дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:
 - 5.3.1. МУТС эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор хамтран ажиллагч болон харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгч болон улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоохтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх тухай;
 - 5.3.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл болон эрх бүхий байгууллагаас МУТС, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбогдуулан гаргасан санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх тухай;
 - 5.3.3. Мэдээлэх үүргийн дагуу харилцагчийн хөрөнгө, бэлэн мөнгөний гүйлгээ, сэжигтэй гүйлгээ болон бэлэн бус мөнгөний гүйлгээг мэдээлэх, тайлагнах тухай;
 - 5.3.4. Мэдээллийн нууцлалыг хадгалах тухай;

- 5.3.5. Харилцагчийг таньж мэдэх ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээлэл, баримт бичиг, гэрээ, санамж бичиг, дансны мэдээлэл, сэжигтэй гүйлгээтэй холбоотой баримт, материал зэргийг хадгалах тухай;
- 5.3.6. МУТС тэмцэх тухай хууль болон холбогдох бусад журам, зааврын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дотоод сургалтын хөтөлбөрийн тухай;
- 5.3.7. Бусад шаардлагатай гэж үзсэн үйл ажиллагааг зохицуулах заавар, аргачлал, зохицуулалтын тухай.

--ooOoo--

